



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 8 сарын 30 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

### Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дархан зочид буудал” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 89,453 /наян есөн мянга дөрвөн зуун тавин гурав/ ширхэг хувьцааг 100 хувааж нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 8,945,300 /найман сая есөн зуун дөчин таван мянга гурван зуу/ ширхэг энгийн хувьцаа болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Дархан зочид буудал” ХК-ийн хувьцааг хуваахтай холбоотой ажиллагааг ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэж, холбогдох тайланг ирүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН